

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар: 14

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах
тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.

2. Хуваарилсан ногдол ашгаас 500,000,000 (таван зуун сая) төгрөгийг татварт тооцож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолыг үндэслэн төрийн өмчийн хувьцаанд ногдох 1,115,450,000 (нэг тэрбум нэг зуун арван таван сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, 3,384,550,000 (гурван тэрбум гурван зуун наян дөрвөн сая таван зуун тавин мянган) төгрөгөөр “Үндэсний давхар даатгал” ХК-ийн нөхөн төлбөрийн нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д тус тус үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн хувьцаанд ногдох ногдол ашгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн 100900000702 тоот дансанд 2022 оны 4 дүгээр улиралдаа багтаан төвлөрүүлж, гүйцэтгэлийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигч (Сангийн сайд)-д танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (З.Энхболд)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Б.Шаравсамбуу)-нд тус тус даалгасугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД